НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
Иргэдэд үйлчлэх төв байр, Чингисийн өргөн чөлөө,
20 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042
Утас: 7777-1965, Факс: (976-11) 34-44-77
E-mail: info@khanuul.mn
http://www.khanuul.mn

2021.02.22 № 11/211

танай ______-ны №______-т

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХЭЛТЭС, АЛБАДЫН
ДАРГА НАРТ

Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудад авлигын эсрэг арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангахад арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиг үүргийн хүрээнд авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний загвар боловсруулж ирүүлснийг уламжилж байна.

2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтын дагуу боловсруулж, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан, гүйцэтгэлийн тайланг 2021 оны 05 дугаар сарын 10, 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн тасагт албан бичгээр болон цахимаар /Файл хэлбэрээр/ /raisatolyatti2@gmail.com/ хаягт ирүүлнэ үү.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХБАЯР

1170200311

НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 15160-0035
Утас/Факс: (976-11) 32-71-99
http://www.ulaanbaatar.mn

2021.02.16 № 03/1726

танай ______________-ны №______________-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудад авлигын эсрэг арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангахад арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиг үүргийн хүрээнд авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний загвар боловсруулж ирүүлснийг уламжилж байна.

2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтын дагуу боловсруулж, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан, гүйцэтгэлийн тайланг 2021 оны 06 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ үү.

Хавсралт 6 хуудастай.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.ОЮУНЧИМЭГ

D:\2021 он\A- 5TG.docx
111020000727

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2021.01.19 № 01/696

танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР
ТАНАА

Авлигын эсрэг үйл ажиллагааг
эрчимжүүлэх тухай

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасан "улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих" чиг үүргийн хүрээнд төрийн байгууллагуудад авлигын эсрэг арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангахад арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэн, үйл ажиллагааны үр дүнг үнэлж, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулдаг.

Өнгөрсөн хугацаанд төрийн байгууллагууд өөрийн онцлогт тохируулан, салбар, нэгж, нутаг дэвсгэрийн хэмжээнд авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөж ирсэн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, үнэлж, дүгнэх, ажлын үр дүнгийн үзүүлэлтээр нь эрэмбэлэн жагсаахад хүндрэл бэрхшээл учирч байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний загвар боловсруулсан бөгөөд энэ нь авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн татан оролцуулах, ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсний зэрэгцээ авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлыг олон нийтэд тасралтгүй хүргэхтэй холбоотой арга хэмжээг багтаасан болно.

Иймд 2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт загварын дагуу боловсруулж, байгууллагынхаа цахим хуудсанд байршуулан, гүйцэтгэлийн тайланг зураг, тоон үзүүлэлт, богино хэмжээний дүрс бичлэг зэргээр баримтжуулан, дүгнэх хуудсыг хавсарган, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл,ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал, хүсэлтээ тусган 2021 оны 06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт тус тус ирүүлж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авна уу.

Хавсралт: 5 хуудас.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР З.ДАШДАВАА

0001762

Авлигатай тэмцэх газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын -ны өдрийн ..... /..... дугаар албан бичгийн хавсралт

# ДҮГНЭХ ХУУДАС

| № | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоон үзүүлэлт | Хамруулсан хүний тоо |
|---|---|---|---|
| 1. | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал; | | |
| 2. | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг) зэргээр сурталчилсан байдал; | | |
| 3. | Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг дэмжиж ажилласан байдал; | | |
| 4. | Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг орон нутаг, салбартаа зохион байгуулсан байдал; | | |
| 5. | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах мэдээллийн булан, самбар тогтмол ажиллуулсан байдал; | | |
| 6. | Авлигын эсрэг сургалтын санал, захиалга өгсөн байдал; | | |
| 7. | Авлигын эсрэг сургалтад шинээр томилогдсон албан хаагчаа хамруулсан байдал; | | |
| 8. | Авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байдал; | | |
| 9. | Иргэд, олон нийт, хүүхэд залуучуудад зориулан авлигын эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байдал; | | |
| 10. | Иргэд, олон нийт, хүүхэд залуучуудад зориулан соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байдал; | | |
| 11. | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд арга хэмжээг зохион байгуулсан байдал; | | |
| 12. | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал; | | |
| 13. | Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байдал; | | |
| 14. | Авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр шинэ шийдэл, сайн туршлага, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байдал; | | |

6-дугаар зүйлийг дүгнэх хуудас

/Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд зааснаар доорх мэдээллүүдийг цахим хуудас дээрээ байршуулж, иргэд үзэж, танилцах боломжоор хангах/

| д/д | Мэдээллүүд | Байршуулсан | Байршуулаагүй | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 15 | Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байдал; | | | |
| 16 | Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байдал; | | | |
| 17 | Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/ | | | |
| 18 | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/ | | | |
| 19 | Дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/ | | | |
| 20 | 9.1.4.2.Жилийн эцсийн санхүүгийн тайлан /5 дүгээр сарын 1-ний дотор/ | | | |
| 21 | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /5 дүгээр сарын 1-ний дотор/ | | | |
| 22 | Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/ | | | |
| 23 | Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/ | | | |
| 24 | Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр,Хагас жилээр) | | | |
| 25 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) | | | |
| 26 | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) | | | |
| 27 | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээлэл; | | | |
| 28 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө | | | |
| 29 | Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга | | | |
| 30 | Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогч-ийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/ | | | |
| 31 | Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан | | | |
| 32 | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн | | | |
| 33 | Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр) | | | |
| 34 | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 35 | Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Бүтэн жил, сар бүр/ орон нутагт хамааралтай | | | |
| 36 | Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Сар бүр) орон нутагт хамааралтай | | | |
| 37 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) | | | |
| 38 | Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/ | | | |
| 39 | Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журам | | | |
| 40 | Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа | | | |
| 41 | Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээлэл | | | |
| 42 | Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэл | | | |
| 43 | Ёс зүйн дүрэм | | | |
| 44 | Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдал /тушаал, захирамж/ | | | |
| 45 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, заавар | | | |
| 46 | Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах | | | |
| 47 | Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) | | | |
| 48 | Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх | | | |
| 49 | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуц-сан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь | | | |
| 50 | Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаарх мэдээлэл | | | |
| 51 | Сул орон тооны зар /тухай бүр шинэчилсэн/ | | | |
| 52 | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам | | | |
| 53 | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр) | | | |

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2021 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн үзүүлэлт |
|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк. твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх; | -Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх |
| | | 1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах; | -Дэмжиж хамтран ажилласан байх<br>-Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх |
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах; | -Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх<br>-Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх |
| 2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг нараа АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах | 2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлсэн байх; | -Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх |
| | | 2.2.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх; | -Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо |
| | | 2.3.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуус хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх; | -Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх,<br>-Хамрагдсан хүүхэд залуус, иргэд тоо |
| 3 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг | 3.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж,<br>3.2.Мөрдөгчийн мэдэгдэл,<br>3.3.Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ; | -Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх |

| | | | |
|---|---|---|---|
| | хугацаанд нь мэдэгдэх | | |
| 4 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 4.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал; | |
| | | 4.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | |
| 5 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх/ Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ | -Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх |
| 6 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах | • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах; | -Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх |

.....o0o.....

| Д/д | Хэлтэс |
|---|---|
| 1 | Нийгмийн даатгалын хэлтэс |
| 2 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс |
| 3 | Албан бус насан туршийн боловсролын төв |
| 4 | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв |
| 5 | Мэргэжлийн хяналтын хэлтэс |
| 6 | Боловсролын хэлтэс |
| 7 | Газрын алба |
| 8 | Гэр, бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс |
| 9 | Дотоод аудитын алба |
| 10 | Онцгой байдлын хэлтэс |
| 11 | Татварын хэлтэс |
| 12 | Улсын бүртгэлийн хэлтэс |
| 13 | Худалдан авах ажиллагааны алба |
| 14 | Цагдаагийн нэгдүгээр хэлтэс |
| 15 | Цагдаагийн хоёрдугаар хэлтэс |
| 16 | Замын цагдаагийн хэлтэс |
| 17 | Эрүүл мэндийн төв |
| 18 | Нэгдсэн эмнэлэг |
| 19 | Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ |